



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 1/624.

Зуунмод

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах арга хэмжээний тухай” 2012 оны 222 дугаар тогтоолын 11, 2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр хураамж, үйлчилгээний хөлс, хандив тусlamж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлийг цоорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Дэд зөвлөлийн дарга: -Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Хөгжлийн бодлогын хэлтсийн байгаль орчин хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

-Аймгийн Татварын хэлтсийн дарга

-Байгаль орчны газрын дарга

-Аймгийн ажил олгогч эздийн холбооны тэргүүн

-Байгаль орчны иргэний зөвлөлийн аймгийн салбарын тэргүүн

-Иргэдэд мэдээллээр үйлчлэх төвийн менежер

-“Заамар нутгийн хөгжилд миний оролцоо” ТББ –ийн тэргүүн

2. Дээрх тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг дэд зөвлөлийн дарга /Н.Мөнхбаатар/-т даалгасугай.

3. Энэ захирамжийн биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Д.Нямдорж/-т үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 93 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Н.МӨНХБААТАР

1 147